



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/307

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Арга хэмжээний эрх шилжүүлэх тухай" А-35 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөлтэй хамтран аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн агуулахыг Арвайхээр суманд барихад шаардагдах орон нутгийн оролцооны 30 хувь болох 48,000,000 (дөчин найман сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 48,000,000 (дөчин найман сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100650